



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/407

Мандалговь

Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх,
ашиглалтад оруулах арга хэмжээний тухай

Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.2 дахь заалтууд, 37 дугаар зүйлийн 37.1.4 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 170 дугаар тогтоолын 3.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 211 дүгээр тушаалаар батлагдсан "Барилга, байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах зориулалт, хүчин чадлыг тогтоох журам"-д заасан бага, дунд, өндөр, онцгой төвөгшлийн ангилалд хамаарах барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүйгээр барилга угсралтын ажилд захилагчийн хяналтын гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж)-д үүрэг болгосугай.

2. Магадлал хийгдсэн зураг төсөвгүй, захиалагчийн хяналт гүйцэтгэх болон зохиогчийн хяналт хийх гэрээ байгуулаагүй, барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөлгүй барилга байгууламжийг ашиглалтад оруулахгүй байхыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/405 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210578